

болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Handwritten signature of Ch. Erdenebaatar

Ч.ЭРДЭНЭБААТАР

- Амраалт 1. Агуулга
- Амраалт 2. Аудитын гэрчилгээ
- Амраалт 3. Мөнгөний тэнгэр зөвшилцөл
- Амраалт 4. Аудит жилийн санхүүгийн тайлан
- Амраалт 5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

114

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ГУРВАНБАЯН ТОСГОНЫ ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Эмэлт мэдээлэл авахыг хүсвэл
араах хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

АБ-ын Тэргүүлэх аудитор
Тас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Тас: 70562147
Цахим хаяг:

Аудитор: Ж.Болор-Эрдэнэ
Тас: 70562147
Цахим хаяг:

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ГАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

ГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/73/СТА-ТШЗ/ аудит явилээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 03 дүгээр сарын 07 -ноос 2018 оны 03 дугаар сарын 11-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Ж.Болор-Эрдэнэ хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дугаар сарын 25-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 03 дугаар сарын 07 -ноос 2018 оны 03 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 12-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3.1.-д Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь “бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ

119

дэмжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хэрэгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар хуулийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар удирдаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн эрхлэгч Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 5-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг зарцуулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг өлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн анхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 148.2 сая төгрөгийн анхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 147.1 сая төгрөгийг зарцуулж, 1.1 сая төгрөгийг өсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд 2017 оны байгууллагын үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн талаарх мэдээлбэл зохих 149 мэдээллээс 65 нь хугацаандаа, 82 нь хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 5 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөхгүй байх нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад илэрүүлэн тэмдэглэв. Аудитын явцад материаллаг ба материаллаг бус хэмжээний дараах асуудлаа илэрсэн байна. Үүнд:

1. 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдөр Хуласт Хурх ХХК-нд нэгжний үнэ **390,0** мянган төгрөгийг шуудан холбооны зардлаас шилжүүлж, нэгжийг хэнд олгож, хэрхэн зарцуулсан тайлан байхгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн байгаа нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгөх.

2. 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр БИТАЧИ ХХК-нд сургалтын хэрэглэгдэхүүн /тавиур, тоглоом/-ны үнэ **3000.0** мянган төгрөг, 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдөр, Сүндэр Өргөө трейд ХХК-нд камерны үнэ **1404.9** мянган төгрөгийг тус тус шилжүүлэхдээ анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, мөн үндсэн хөрөнгөнд орлого аваагүй, бараа материалын дансанд орлогоор зөвшөөрч бүртгэсэн нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, мөн санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын Үндсэн хөрөнгө 4.30-г тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: 1. Илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгөх.
 2. 4119.4 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын данснаас шилжүүлэн үндсэн хөрөнгийн дансанд орлого авч, санхүүгийн тайланд залруулга хийх.

3. Тайлант оны төвлөрүүлсэн төсвийн үлдэгдэл **1069.4** мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн орлогоос хасаж илэрхийлээгүй нь, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийх.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дараагийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

100

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 10,0 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 5.2 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 4.8 сая төгрөгийн 3 алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил үйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, аудитын гэрчилгээ 2 хуудас, менежментийн захидал 4 хуудсыг тус тус хавсаргав.


Аудитын тайланг

Хянасан:

Тэргүүлэх аудитор

Аудитын менежер

Аудитор



/ Ч.Эрдэнэбаатар/

/ Д.Оюунтуяа/

/ Ж.Болор-Эрдэнэ/

Бэлтгэсэн:

Огноо: 2018.03.05

Мөнхий аймаг дахь Төрийн
аудитын газар

ГУРВАНБАЯН ТОСГОНЫ ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Анхан шатны баримт бүрдэлийн талаар

Асуудал 2
Шилэн дансны мэдээллийн талаар

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг бэлтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд үнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн зайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, эргэжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Гурванбаян тосгоны Цэцэрлэгийн эрхлэгч О.Урангоо, нягтлан бодогч Ч.Уянганэмэх нарт талархал илэрхийлье.

Товчоо 1: Анхан шатны баримт бүрдэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

АГ-ын ажиглалт

1. 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр БИТАЧИ ХХК-нд сургалтын хэрэглэгдэхүүн /тавиур, тоглоом/-ны үнэ **3000.0** мянган төгрөг,
2. 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдөр, Сүндэр Өргөө трейд ХХК-нд камерны үнэ **1404.9** мянган төгрөг,
3. 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдөр Хуласт Хурх ХХК-нд нэгжний үнэ **390,0** мянган төгрөгийг тус тус шилжүүлэхдээ анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн нь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг зөрчиж, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

АГ-ын зөвлөмж

1. Анхан шатны баримтын бүрдэлийг бүрэн хангаж ажиллах. Цаашид холбогдох хууль, журмыг зөрчихгүй байхыг зөвлөж байна.

Эрсдэлүүд

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ гаргаж, мөнгө зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Түүвэл 2: Шилэн дансны талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

АГ-ын ажиглалт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад:

Нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа нь болоогүй 2 мэдээ, мэдээлсэн 147 мэдээллээс 65 нь хугацаандаа мэдээлсэн, 82 нь хугацаа хоцроосон нь "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

АГ-ын зөвлөмж

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээллийг цаг тухайд нь мэдээлж байх.
2. Мөн байгууллагадаа мэдээллийн самбар байнга ажиллуулж, байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажсан мэдээллийг байршуулж олон нийтийг мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангаж ажиллах.

Эрсдэлүүд

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.


МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Ж.БОЛОР-ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:

Огноо: 2018.03.05